



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭДЭЭ

130 /130/

2021.09.08

## “ЗАМ-2021” СУРГАЛТ БАРИЛГА, ИНЖЕНЕРИЙН РОТЫН БЭЛТГЭЛИЙГ ХАНГАЖ БАЙНА



Монгол Улсын БХЯ, Япон Улсын БХЯ хооронд байгуулсан хэлэлцээрээр “Монгол Улсын Зэвсэгт хүчний инженерийн салбарын чадавхыг нэмэгдүүлэх” хөтөлбөрийг Монгол Улсын Зэвсэгт хүчний инженерийн мэргэжлийн офицер, ахлагч нарыг зам барих аргад сурган дадлагажуулах, багшлах бүрэлдэхүүнийг бэлтгэх, мэдлэг, ур чадварыг нь нэмэгдүүлэх, туршлага солилцох зорилгоор Япон Улсын БХЯ-аас боловсруулж, 2014 оноос эхлэн хэрэгжилтийг 12 удаагийн сургалт, дадлагаар хангаад байгаа юм. Дээрх зам сургалт дадлагад хамрагдсан бие бүрэлдэхүүн улс орны бүтээн байгуулалтын ажилд гол цөм нь болж үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд энэ нь

зам сургалтын үр дүнгийн нэгээхэн хэсэг юм. Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх “Барилга, инженерийн рот”-ын бэлтгэлийг хангах, үндсэн мэргэжилтэн бэлтгэх гол зорилготой энэ удаагийн сургалтад хоёр орны 60 гаруй алба хаагч, 15 нэгж техник оролцож, нийт 200 метр газарт сайжруулсан шороон зам, хоёр иж бүрэн гүүр хоолой барих юм байна. Сургуулийн удирдагчаар Монголын талаас Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа Г.Мөнхбат, Японы талаас Япон Улсын Зүүн хойд бүс нутгийн инженерийн II

ангийн хошууч Томоюки Сато нар томилогдон үүрэг гүйцэтгэж байгаа аж. Өмнөх сургалтуудад Японы талаас ирсэн сургагч багш нарын зааварчилгааны дагуу бүх хэмжилт болон бусад замын ажил хийгддэг байсан бол энэ удаа монгол цэргүүд өөрсдөө гардан гүйцэтгэж байна. Өөрөөр хэлбэл, сургалтад хамрагдаж буй монгол цэргийн алба хаагчид хэмжилт хэрхэн хийх, газар оронд зам, далан, гүүр хоолойг яаж барих, газар орныг ямар аргачлалаар үнэлэх зэрэг олон чухал чадваруудад суралцсанаа дадлагаар бататгаж байна. “Зам-2021” сургалт энэ сарын 14-ний өдөр өндөрлөнө.

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
9	3

#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
31	22

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.849.0	2.851.0
EUR	3.385.0	3.400.0
CNY	442.0	443.5
RUB	38.50	39.60
JPY	25.73	26.17
KRW	2.42	2.51

### ЗУРХАЙ

2021.09.08 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 2/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН ХАРЦАГА ОДТОЙ, ШАРАГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:  
Эрлэг лугаа учирна  
Наран ургах, шингэх:  
06.20-19.20  
Барилдлага:  
Арвидах  
Шүтэн барилдлага:  
Нэр өнгө  
Суудал:  
Төмөр

Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, эрдэнийг гадагш өгөх, мал худалдан авах, мал түгээх, сахил санваар авах, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## “РЕДАКЦЫН УУЛЗАЛТ”-Д УРЬЖ БАЙНА

Зэвсэгт хүчний Жанжин штаб, БХЯ-ны харьяа “Соёмбо” редакц, Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулга хамтран Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын Соёл хүмүүжлийн ажилтнуудтай хийх “Редакцын уулзалт”-ыг энэ сарын 9-ний өдөр зохион байгуулах гэж байна. Монголын соёл урлагийн ажилтны өдөр, Зэвсэгт хүчинд Улс төр, соёлын байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулж буй энэхүү уулзалтын зорилго нь цэргийн соёл хүмүүжлийн ажлын уламжлал, шинэчлэл, өнөөгийн байдал, хэтийн төлөв болон цэрэг дайчдын дунд

зохион байгуулах соёлын ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх, олон нийтэд мэдээлэн сурталчлах талаар харилцан туршлага солилцох явдал юм. Уулзалтад БХЯ-ны “Соёмбо” редакцийн дарга, хурандаа С.Төмөрхуяг, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Суртал хүмүүжил, мэдээлэл, сэтгэл зүйн хэлтсийн Суртал хүмүүжлийн ажлын төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн, хурандаа Т.Мөнхсаруул, ЦДБЭЧ-ийн Сургалт, соёл хүмүүжил, маркетингийн албаны дарга, дэд хурандаа Р.Өнөржаргал, “Зэвсэгт хүчний Улс төр, соёлын ажилтны

холбоо” ТББ-ын Гүйцэтгэх захирал, хурандаа Н.Энхболд нарын албаны бусад хүмүүс оролцохоос гадна ЦДБЭЧ-ын уран бүтээлчид хэсэгчилсэн тоглолт сонирхуулах юм. Иймд Зэвсэгт хүчний Улаанбаатар цэргийн хүрээний ангиудын Соёл хүмүүжлийн ажилтнууд Та бүхнийг 2021 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 13 цагт Офицеруудын ордны “Соёмбо” танхимд зохион байгуулах “Редакцын уулзалт”-д хүрэлцэн ирэхийг урьж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 99711435 /дэд хурандаа Р.Өнөржаргал/ дугаарт холбогдон авах боломжтой.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 237.271	ЭДГЭРСЭН 215,109	НАС БАРСАН 976
+3963	+3560	+8

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4749	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 185	ЭДГЭРСЭН 4473
+82	+15	+16

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 222,712,067
Эдгэрсэн Нийт: 199,228,216
Нас барсан Нийт: 4,598,356

### ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД АА!



ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД АА!  
ЭМЧНД ЯАРАЛТАЙ ХАНДААРАЙ!

## ЦЭРЭГЖЛИЙН СПОРТЫН ТЭМЦЭЭН АМЖИЛТТАЙ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Энэ сарын 6-ны өдөр нээлтээ хийсэн Зэвсэгт хүчний 2021 оны аварга шалгаруулах цэргийн 3 төрөлт, цэрэгжлийн буудлага, туухай өргөлт, цэрэг спортын цогцолборын зуны олон төрөлт, саадын зурвасын тэмцээн Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Хужирбулан дахь Сургалтын төвд үргэлжилж байна.

Энэхүү тэмцээний Автомат буудлагын эрэгтэй төрөлд ахлах ахлагч Ж.Оюунгэрэл /013/, Б.Төртогтох /015/, сургагч ахлагч Г.Хатанбаатар /084/, эмэгтэй төрөлд ахлагч

А.Эрдэнэчимэг /016/, Ариунтунгалаг /011/, хошууч Б.Батдэмбэрэл /029/,

Гар бууны тогтоол буудлагын эрэгтэй төрөлд хошууч Л.Соронзонболд /015/, дэд хурандаа Д.Сүхбат /256/, хошууч Б.Хэнзээ /124/, эмэгтэй төрөлд ахлах ахлагч Н.Эрдэнэсүвд /119/, хошууч Д.Эрдэнэбулган /065/, ахлах дэслэгч Б.Оксана /110/,

Хурдан буудлагын эрэгтэй төрөлд ахмад П.Оюунбат /084/, М.Болд-Эрдэнэ /013/, хошууч П.Баярхүү /326/, эмэгтэй төрөлд ахлагч А.Саранзаяа /331/, ахмад

Т.Дэлгэрмаа /032/, ахмад Б.Хандсүрэн /330/, Эрэгтэй багийн нэгдсэн дүнгээр хурандаа Н.Бат-Эрдэнэ /310/, Д.Шинэбаяр /084/, Ц.Батсайхан /015/, Эмэгтэй багийн нэгдсэн дүнгээр хурандаа Ц.Буянжаргал /311/, Ж.Мөнхбаяр /032/, Н.Бат-Эрдэнэ /330/ нар тэргүүлж, амжилт үзүүлээд байна.

Цар тахлаас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийг хатуу чанд мөрдөн зохион байгуулж буй энэ тэмцээнд олон улсын хэмжээний мастер 3, спортын мастер болон дэд мастер тус бүр 10 гаруй,

цэрэгжлийн спортын мастер 30 гаруй, цэрэгжлийн спортын зэрэгтэй тамирчин 50 орчим, түүнчлэн 20 гаруй түүрүүч, байлдагч нар оролцож байна.

Ташрамд сонирхуулахад, энэ жил туухай өргөлтийн тэмцээнийг Зэвсэгт хүчний хэмжээнд цахим хэлбэрээр зохион байгуулж байгаа нь холбоо, мэдээллийн технологийн давуу байдлыг ашиглах, цаашид энэ хэлбэрээр уралдаан, тэмцээнийг зохион байгуулах боломжийг эрэлхийлсэн ач холбогдолтой алхам болж байгаа юм.

### Фото мэдээ

Манай сурвалжлагч, дэслэгч Т. ИДЭР ОХУ-аас мэдээлж байна

Олон улсын стратегийн "Запад-2021" хамтарсан хээрийн сургуульд оролцох Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн баг ОХУ-ын Зэвсэгт хүчний Баруун цэргийн тойргийн "Мулино" сургалтын төвд байрлаж байна.

Энэ жилийн сургуульд Монгол Улсын Зэвсэгт хүчний төлөөлж, удирдлагын бүлэг, мотобуудлага болон танкийн салааны бүрэлдэхүүнтэйгээр оролцож байгаа бөгөөд тэд бэлтгэлээ хангаж, үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

## "ЗАПАД-2021" СУРГУУЛЬ ГАРААНААС ГАРЛАА

